# Asian Productivity Organization
# “The APO in the News”

Name of publication: Unuudur (7 April 2014, Mongolia)
Page: D2

## Азийн Бүтээмжийн Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга Мари Амано Монгол Улсад албан ёсны айлчлал хийлээ



Азийн Бүтээмжийн Байгууллага (АББ) нь 1961 онд байгуулагдсан бүс нутгийн засгийн газар хоорондын байгууллага юм. Энэхүү байгууллагын гол чиг үүрэг нь Ази Номхон Далайн бүс нутгийн 20 гаруй гишүүн орнуудтай хамтран тэдгээрийн бүтээмжийг дээшлүүлэн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмрээ оруулах явдал юм. АББ-ын Төв нь Токио хотод байрладаг.

АББ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Мари Амано Монгол Улсад анх удаа 4 дүгээр сарын 1-2-ны өдрүүдэд айлчилсан байна.

Айлчлалын зорилго нь Монгол Улсын төрийн байгууллагуудын төлөөлөл болох УИХ, ЗГХЭГ, Хөдөлмөрийн Яам, Гадаад Хэргийн Яам, Барилга, Хот байгуулалтын яамны сайд, дарга нартай уулзаж улс орны бүтээмж, нийгэм, эдийн засгийн хөгжлийн асуудлаар санал солилцож, Монголын Бүтээмжийн Төвийн үйл ажиллагаатай танилцсан явдал байлаа.

Мөн АББ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Мари Амано Монголын Бүтээмжийн Төвөөс 4 дүгээр сарын 2-нд зохион байгуулсан "Чанарын дугуйлангуудын туршлага солилцох" чуулга уулзалтад хүрэлцэн ирж, уг чуулга уулзалтыг нээж үг хэлсэн юм.

Энэхүү айлчлалын ач холбогдол нь хоёр талын хамтын ажиллагааг бэхжүүлж, манай улсын төрийн байгууллагуудын зүгээс бүтээмжийн үйл ажиллагааг ойлгох, дэмжлэгийг нэмэгдүүлэхэд оршино.

Манай улс АББ-ын гишүүнээр 1992 онд элссэн бөгөөд Үндэсний Бүтээмж, Хөгжлийн Төв (Одоогийн Монголын Бүтээмжийн Төв) байгуулагдан Монгол Улсад бүтээмжийн шинэлэг үзэл баримтлалыг түгээн дэлгэрүүлэх, аж ахуйн нэгж байгууллагуудын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр олон төрлийн үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэн 20 гаруй жил ажиллаж байна.

Энэ үйл ажиллагааны хүрээнд Азийн 21 оронд олон улсын сургалт семинар, хурал уулзалтад Монгол Улсаас төлөөлөгч оролцуулах, хамтарсан сургалт арга хэмжээ, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр үйл ажиллагаа явуулж байна.